

**ХҮНС, ТЭЖЭЭЛИЙН САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ  
БҮГД НАЙРАМДАХ ИТАЛИ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ,  
МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ХООРОНДЫН  
ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ**

Бүгд Найрамдах Итали Улсын Эрүүл мэндийн яамны Хүнс, тэжээлийн эрүүл ахуй, аюулгүй байдлын ерөнхий газар, Монгол Улсын Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /цаашид “Талууд” гэх/;

2012 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Бээжин хотод /БНХАУ/ гарын үсэг зурсан Бүгд Найрамдах Итали Улсын Эрүүл мэндийн яам, Монгол Улсын Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам хооронд мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах техникийн хэлэлцээрийг үндэслэн;

Цаашид хоёр улсын хүнс, тэжээлийн салбар дахь хамтын ажиллагааг бэхжүүлэхийг зорин;

Энэхүү хамтын ажиллагаа нь тус тусын хүн амын эрүүл мэндийн нөхцөлийг сайжруулахад хувь оруулж болохыг ойлгон;

Дор дурдсан зүйлсийг тохиролцов:

**Нэг. Зорилго**

1.1 Талууд хүнсний хяналт болон тэжээлийн салбар дахь хамтын ажиллагааг дэмжиж, өсөн нэмэгдэж буй хүнс, тэжээлийн нийлүүлэлт болон эрүүл, аюулгүй гадаад худалдааг хөгжүүлнэ.

1.2 Талууд тус тусын ашгийг харгалзан үзэж, хуулийн дагуу эрх тэгш хамтран ажиллана.

**Хоёр. Хамрах хүрээ**

Талууд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд хичээн ажиллах болно. Үүнд:

- Тус тусын улсын хүнсний хяналт болон тэжээлийн салбарт мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм журам болон бусад холбогдох бичиг баримтыг солилцоно;
- Хоёр улсын холбогдох байгууллага, албан газартай шууд харилцана;
- Мэргэжилтнүүдийг харилцан солилцож, төлөөлөгчид болон мэргэжилтнүүдийг Талуудын зохион байгуулж байгаа хяналтын салбар дахь шинжлэх ухааны уулзалт, хуралд оролцуулна;
- Хүнсний салбар дахь экспорт, импортын хяналт шалгалттай холбоотой гарсан зөрчил дутагдал, яаралтай мэдээлэх системийн мэдээллийг солилцож,

шинжлэх ухааны үндэслэлтэйгээр харилцан нөхөрсгөөр зөвшилцсөний дагуу шийдвэрлэнэ;

- Хоёр орны хүнсний шинжилгээний лабораторитой холбоотой лабораторийн арга аргачлал, мэргэжилтнүүд болон лабораторийн зохистой дадлыг харилцан солилцоно;
- Монгол Улсын стандартуудыг Европын Холбооныхтой нийцүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ;
- Хамтын ажиллагааны аливаа бусад хэлбэрийг харилцан тохиролцсоны үндсэн дээр хэрэгжүүлнэ.

### **Гурав. Хэрэгжилт**

3.1 Талууд хамтын ажиллагааны хүрээн дэх тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох, Гүйцэтгэлийн төлөвлөгөөг сайжруулах мөн хамтын ажиллагааны талаар тус тусын удирдлагуудыг цаг үеийн мэдээллээр хангах үүрэг бүхий хамтран ажиллах Хороог байгуулна. Хороо нь Талуудаас доод тал нь гурван гишүүнийг багтаасан байх бөгөөд Талуудын ахлах албан тушаалтнаар ахлуулсан байна. Энэхүү ажлын хэсэг нь Талууд зөвшөөрсний үндсэн дээр ямар ч тохиолдолд жилд нэгээс дээшгүй удаа Бүгд Найрамлах Итали Улс болон Монгол Улсад уулзалт зохион байгуулах ба уулзалт нь Талуудын томилсон мэргэжилтнүүдийн санаачилгаар өөр өөр аргачлалтай байж болно.

### **Дөрөв. Зардал**

4.1 Энэхүү Харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээн дэх үйл ажиллагаа нь Талуудын санхүүгийн төсвийн хүрээнд явагдана.

4.2 Талууд 2 дахь хэсэгт дурдсан үйл ажиллагаануудыг явуулах газрыг харилцан зөвшилцөн шийднэ.

4.3 Богино хугацааны хөтөлбөрийн үед хүлээн авагч улс нь үйл ажиллагааг зохион байгуулахтай холбогдсон зардлыг хариуцаж, ирж байгаа Тал нь мэргэжилтэн болон албан хаагчдыг оролцуулах бол замын зардал, байрлах байр болон унаа, тээврийн зардлыг хариуцна.

4.4 Урт хугацааны хөтөлбөрийн үед, Талууд санхүүгийн талаар тухай бүрд зөвшилцөн шийднэ.

### **Тав. Бусад эрх, үүрэг**

5.1 Энэхүү Харилцан ойлголцлын санамж бичгийн хэрэгжилт болон бусад үүнтэй холбоотой үйл ажиллагаа нь Талуудын тус тусын хууль дүрмийн дагуу Итали Улсын Европын холбооны гишүүний үүргийг хөндөхгүйгээр явагдана.

5.2 Энэхүү Харилцан ойлголцлын санамж бичиг нь Талуудын олон улсын эрх, үүрэгт нөлөөлөхгүй.

## **Зургаа. Хүчин төгөлдөр болох, засвар болон нэмэлт оруулах**


Энэхүү Харилцан ойлголцлын санамж бичиг нь гарын үсэг зурсан өдрөөс эхлэн таван жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна. Хүчинтэй хугацаа дуусахаас доод тал нь зургаан сарын өмнө аль нэг тал нь санамж бичигт өөрчлөлт оруулах буюу цуцлах саналаа нөгөө талдаа албан ёсоор бичгээр мэдэгдээгүй тохиолдолд дахин таван жилийн хугацаагаар сунгагдах болно.

Талууд санамж бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд эдгээр нэмэлт, өөрчлөлт нь санамж бичгийн салшгүй хэсэг болно.

Харилцан ойлголцлын санамж бичгийн ямар нэгэн өөрчлөлт нь үнэхээр шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хийгдэнэ.


Энэхүү санамж бичигт 2015 оны ..... дүгээр сарын ..... -ны өдөр .....-д гарын үсэг зурж итали, монгол, англи хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд хувиуд адил хүчинтэй байна. Ойлголцлын зөрүү гарвал англи эх хувийг баримтална.

**БҮГД НАЙРАМДАХ ИТАЛИ  
УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ЯАМЫГ ТӨЛӨӨЛЖ**



---

**МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН  
ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛЖ**



---